



СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХ¹⁷

Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн

- ✓ үндэс, угсаа,
- ✓ хэл,
- ✓ арьсны өнгө,
- ✓ хүйс,
- ✓ нийгмийн гарал, байдал,
- ✓ хөрөнгө чинээ,
- ✓ эрхэлсэн ажил, албан тушаал,
- ✓ шашин шүтлэг,
- ✓ үзэл бодол,
- ✓ боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй.

18 нас хүрсэн, иргэний бүртгэлд бүртгүүлсэн, эрх зүйн бүрэн чадамжтай, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэсэн Монгол Улсын иргэнийг **“СОНГОГЧ”** гэнэ.

Харин сонгуулийн тухай хуульд заасан журмын дагуу тухайн сонгуульд нэр дэвшиж бүртгүүлсэн, нэр дэвшигчийн үнэмлэх авсан иргэнийг **“НЭР ДЭВШИГЧ”** гэнэ.

- ✓ 25 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй.
- ✓ 45 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан Монгол Улсын уугуул иргэн Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй.
- ✓ 25 нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, суманд санал авах өдрөөс өмнө 180-аас доошгүй хоногийн хугацаанд тасралтгүй, байнгын оршин суугчаар бүртгүүлсэн, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны орон нутгийн хуралд сонгогдох эрхтэй.
- ✓ УИХ болон орон нутгийн хурлын сонгуулийн санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам, эвсэл сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.
- ✓ Мөн хуульд заасан шаардлага хангасан иргэн Улсын Их Хурлын гишүүнд бие даан нэрээ дэвшүүлэх эрхтэй. Бие даан нэрээ дэвшүүлэгч тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг сонгуулийн төв байгууллагаас баталсан маягтын дагуу зуруулна. Аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь сонгуулийн төв байгууллагын баталсан маягыг бие даан нэрээ дэвшүүлэгчид тэмдэг дарж олгоно. Бие даан нэр дэвшигчээс сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн өөрийн нэр, эцэг (эх)-ийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байна.

¹⁷ Сонгуулийн тухай хуулийн 3, 127 дугаар зүйл, 2 дугаар бүлгээс

Дээрх шаардлагаас гадна дараах шалгуурыг хангасан байна:

- Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа, батлан даалтын өргүй;
- Албан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй;
- Нэр дэвшигч нь аль нэг компанийн 51 ба түүнээс дээш хувьцааг эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй;
- Ял шийтгүүлж байгаагүй, эсхүл ял шийтгүүлж байсан бол ялгүй болсон буюу ялгүйд тооцогдсон;
- УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нь цэргийн жинхэнэ хугацаат алба хаах насны иргэн бол Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийн дагуу цэргийн алба хаах үүргээ биелүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гадаадад оршин суугаа иргэн, өндөр настан болон бусад иргэд эрүүл мэндийн байдлын улмаас сонгуульд санал өгч оролцох боломж нь зарим тохиолдолд хязгаарлагдмал байх тохиолдол гардаг. Харин Сонгуулийн тухай хуулиар дараах боломжийг олгож байна:

- ✓ Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд нэг байна.
- ✓ Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.
- ✓ Эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр хүрэлцэн ирж чадахгүй бол зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх сонгогч нь өөрийн эрүүл мэндийн талаарх эмчийн магадлагааг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн хамт санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргүүлнэ.
- ✓ Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар (Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам; олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар; Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар) байрладаг гадаад улсад байгаа, сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуульд заасан журмын дагуу Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй.



Сонгуульд сонгох болон сонгогдох эрх тэгш эрхийг хангах дараах хуулийн заалтууд хэрхэн хэрэгжиж байгааг ярилцаарай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд Улс төрийн үйл ажиллагаанд оролцох тухай :¹⁸

- Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана.

Мөн хүйсийн тэнцвэртэй байдлыг нэмэгдүүлэх үүднээс Сонгуулийн тухай хуульд нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь **аль нэг хүйсийн** нэр дэвшигч байна гэж заасан байдаг.¹⁹



“Парламент нь ард түмний төлөөллийг хангасан, бүрэлдэхүүн, ажлын арга барилын хувьд ялангуяа эмэгтэйчүүд, үндэсний цөөнх, гадуурхагдсан бүлгүүдийг хамруулж оролцоог илүү сайн хангасан байдаг.”²⁰ гэж Олон улсын парламентын холбооны “Ардчилал ба Парламент” гарын авлагад тодорхойлсон байна.

Үндсэн хуулиараа бид ялгаваргүйгээр төрийн байгууллагад сонгуульд сонгох, сонгогдох эрхтэй, улс төрийн харилцаанд хүн бүр тэгш эрхтэй байдаг ч бодит байдалд тэгш хамрагдаж чадахгүй байгаагийн нэг жишээ нь, УИХ-д сонгогдсон төлөөлөгчдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаггүй, эмэгтэй болон залуу төлөөлөгчдийн тоо хүн амын дунд эзлэх хувьтай харьцуулахад хангалтгүй, бага байдаг байна.

¹⁸ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйл

¹⁹ Сонгуулийн тухай хуулийн 126.2 дугаар заалт

²⁰ “Ардчилал ба Парламент” Олон улсын парламентын холбоо 2006. Хуудас 9 (splp.parliament.mn/files/download/146057)

Нийгмийн бүлэг	Хүн амын тоо ²¹ (2015 оны байдлаар)	Хүн амд эзлэх хувь	УИХ-д эзлэх хувь
Эрэгтэй	1503612	49,2	82,9
Эмэгтэй	1554166	50,8	17,1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	101730	3,3	0
Залуучууд (25-39 настай)	809881	26,5	9,2
Үндэсний цөөнх - Казак үндэстэн	114506	3,7	3,9

Иймээс Сонгуулийн тухай хуульд нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна гэсэн квотыг оруулсан байдаг.

Тэгш байдал, тэнцүү боломжийг олгохын тулд дэлхийн зарим улс оронд хүн амд эзлэх хувь хэмжээгээр парламентын суудалд квот тогтоон хадгалсан байдаг. Тухайлбал 2017 оны 2 дугаар сарын байдлаар:

- Руанда улс Үндсэн хуулиараа шийдвэр гаргах түвшний байгууллагын 30 хувийг эмэгтэйчүүдэд, 80 гишүүнтэй Төлөөлөгчдийн тэнхимийнхээ 24 суудлыг эмэгтэйчүүдэд, гурван суудлыг залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хуваарилсан байдаг.
- Хроват улс парламентын найман суудлыг үндэсний цөөнхөд, гурван суудлыг гадаадад амьдарч байгаа иргэдэд ногдуулдаг.
- Кипр улс үндэстнийхээ онцлогоос хамаарч нийт суудлын 30 хувийг Турк гаралтай кипр үндэстэнд хуваарилж, албан тушаалаа Грек, Турк гаралтай кипр үндэстэнд тэнцүү хуваарилдаг байна.
- Уганда улсад 238 гишүүнтэй парламентдаа 112 дүүрэг тус бүрээс нэгээс доошгүй эмэгтэй гишүүний төлөөлөл орсон байхаар тогтоосон байдаг.

²¹ Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан <http://www.1212.mn/>



УИХ ДАХЬ ТӨЛӨӨЛЛИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДЛЫН ТАЛААР ВИДЕОГ ҮЗНЭ ҮҮ. [ВИДЕО ҮЗЭХ](#)




СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ


СОНГУУЛЬД СОНГУУЛИЙН ЗРХ БУХАЙ ИРГЭН ҮНДЭС, УГСАА, ХЭЛ, АРСНЫ ӨНГӨ, ХҮҮС, НИЙГМИЙН ГАРАЛ, БАЙДАЛ, ХӨРӨНГӨ ЧИНЭЭ, ЭРХЛЭСЭН АЖИЛ, АЛБАН ТУШААЛ, ШАШИН ШҮТЛЭГ, ҮЗЭЛ БЭДЭЛ, БОЛОВСРОЛООР ЯЛГАВАРЛГДАХҮЙГЭР ОРОЛЦОХ ЭРХТЭЙ.



МОНГОЛ УЛСАД



УЛСЫН ИХ ХУРАЛД



МОНГОЛ УЛСЫН НИЙТ ХҮН АМЫН



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД



УЛСЫН ИХ ХУРАЛД



ОДООГИЙН БАЙДЛААР УИХ-Д ТЭДНИЙ ТӨЛӨӨЛӨЛ
0 %
БАЙНА.



МОНГОЛ УЛСАД

25-39 НАС 26.5%






УЛСЫН ИХ ХУРАЛД



25-39 НАС 9.2%









МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

16 дугаар зүйл.
МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ДАРААХ ҮНДСЭН ЗӨХ ЧӨЛӨӨТ
БАСЛЫНТАЙ ЗӨНӨӨ.

9 . ИЭЛД ИРГЭН ТӨЛӨӨЛӨНЧИЙН БАЙГУУЛЛАГААА УЛСЫН
ТӨЛӨЙГ ХАЙРУУЛАХ ХЭРГТ ОРОЛХОХ ЗӨХТӨЙ.
ТӨЛӨЙН БАЙГУУЛЛАГАД СОНГОХ, СОНГОГДОХ ЗӨХТӨЙ...

11 . УЛС ТӨР, ЗҮЙН ЗАСАГ, ИЙГЭН СОЁЛЫН АМЬСГАЛ,
ГЭР БҮЛЭЙН ХАРИЦААНД ЗӨХТӨЙ, ИЭЛТЭЙ ТЭГЭ ЗӨХТӨЙ




Тэгш байдал
Тэнцүү боломж




www.gec.gov.mn



Эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүх бүлгийн төлөөлөл шийдвэр гаргах түвшинд гарвал ямар ач холбогдолтой байх талаар ярилцаарай.